ТАНЫ ТАНИЛ СУРАХ БИЧИГ

МОНГОЛ БИЧГИЙН ЦАГААН ТОЛГОЙ

кирил галиг	латин галиг	үгийн эхэн бичмэл	үгийн эхэн дармал	үгийн дунд бичмэл	үгийн дунд дармал	үгийн адаг бичмэл	үгийн адаг дармал
а	a						
э	e						
и	i						
о у	o u						
ө ү	ö ü						
н	n						
л	l						
м	m						
х эр	q						
х эм	k						
г эр	γ						
г эм	g						

кирил галиг	латин галиг	үгийн эхэн бичмэл	үгийн эхэн дармал	үгийн дунд бичмэл	үгийн дунд дармал	үгийн адаг бичмэл	үгийн адаг дармал
б	b						
нг	ng						
т	t						
д	d						
р	r						
ж з	ǰ						
й	y						
с	s						
ш	š						
ц ч	č						
в	w						

Хатуу, зөөлөн дэвсгэрийг сайн мэдэх нь зөв бичихэд чухал холбоотой.

Үндсэн зурлагын нэр

титим → шүд, өргөс, ацаг
гэдэс — шилбэ, урт шүд
нум — сүүл, орхиц, цацлага
нуруу

Дэвсгэр үсэг

Үгийн дунд, адагт ардаа эгшиггүй, үе битүүлж ордог гийгүүлэгч үсгийг дэвсгэр үсэг гэнэ.

б Гэр Гэм р с д

Хатуу дэвсгэр гэдэг.

н м л нг в й

Зөөлөн дэвсгэр гэнэ.

(в), (й) хоёр дэвсгэр үсэг нь одоогийн монгол хэлэнд эгшиг болжээ. Хатуу дэвсгэрийг «багарсад» гэж тогтоогтун!

I II ХИЧЭЭЛ



Тайлбар

М, Л-ийн ялгах тэмдэг ᠭ ᠵ-үүнийг эвэр буюу гэзэг гэдэг.

Үгийн адагт тохиолдох а, э эгшиг нь өмнөх үсэгтэй нь хамт бичих суул, салангид бичих орхиц гэсэн 2 хэлбэртэй тул үгийн адагт тохиолдох НА, НЭ, МА, МЭ, ЛА, ЛЭ нь мөн хоёр хэлбэртэй байдаг.

Монгол бичиг, кирил галиг, хөрвүүлгийг сайтар тулгаж үз!



Кирил галиг

① мину ном олан. ② ман-у мал олан. ③ ним-а мал эмнэн-э. ④ молом мал маллан-а. ⑤ онул-ун ном олул-а. ⑥ энэ ину энэ он-у нам-ун унэн. ⑦ энэ ину эм-ун ном мөн. ⑧ мину эмун-э алим-а унал-а. ⑨ манан улам нэмэл-э. ⑩ унэн-и илэ номла.

Хөрвүүлэг

① Миний ном олон. ② Манай мал олон. ③ Нэм мал эмнэнэ. ④ Молом мал маллана. ⑤ Онолын ном оллоо. ⑥ Энэ нь энэ оны намын үнэн. ⑦ Энэ нь эмийн ном мөн. ⑧ Миний өмнө алим уналаа. ⑨ Манан улам нэмлээ. ⑩ Үнэнийг ил номло.

Н( )-ээр төгссөн нэр үгэнд дагуулах харьяалахын тийн ялгалын нөхцөл (ы̂ и)

Н( )-ээс бусад гийгүүлэгчээр төгссөн нэр үгэнд дагуулах харьяалахын т/я-ын нөхцөл (ун үн)

→ Гийгүүлэгчээр төгссөн нэр үгэнд дагуулах заахын тийн ялгалын нөхцөл (и). Жишээ:



номын, малын, Моломын, олны, үнэний

III IV ХИЧЭЭЛ



Үеүдийг унш.





Кирил галиг

минү эхэ, молом-ун ах-а, хэлэху үгэ, халагун гал, улаган ном, намхан хүмүн, номухан хонь, манаг-а манаху ун-э үнэлэху, ухаган нэмэху, эгүлэ нэгүху, гүн нагур, минү эмэгэл, эгүн-ү эмүн-э

Хөрвүүлэг

Миний эх, Моломын ах, хэлэх үг, халуун гал, улаан ном, намхан хүн, номхон хонь, манаа манах, үнэ үнэлэх, ухаан нэмэх, үүл нүүх, гүн нуур, миний эмээл, үүний өмнө

Олон дахин бичиж, нүдлэн тогтоо!

Монгол бичигт урт эгшгийг тэмдэглэх гол аргын нэгэн бол **эгшиг + Г + эгшиг** гэсэн нийлэмж юм. Доорхи жишээг ажигла!





Дараахь үгсийг сойтор ялган тогтоо!







Монгол бичигт ирээдүй цагийн нөхцөлийг -ху(хү) гэж бичдэг.



(үйлт нэрийн)

V ХИЧЭЭЛ

ᠪ	эхэн	дунд	адаг
б	ᠪ	ᠪ	ᠪ
ба бэ	ᠪᠠ	ᠪᠠ	ᠪᠠ
би	ᠪᠢ	ᠪᠢ	ᠪᠢ
бо бу	ᠪᠣ	ᠪᠣ	ᠪᠣ
бө бү	ᠪᠥ	ᠪᠥ	ᠪᠥ

Үеийг унш!

бог

бэг

Кирил галиг

би бөмбүгэ абуба. абу бэлэг өгбэ. энэ хэн-ү ном буи. энэ бол мину ном хэблэл мөн биләэ. ман-у ама бүли олан бол-ба. мину ах-а мөлөм-үн хөбэгүн хони имаг-а маллаба. хүмүн бүхүн ном абулуг-а. Мину абаг-а ах-а болху хүмүн эгүн-и хибэ.

Хөрвүүлэг

Би бөмбөг авав. Аав бэлэг өгөв. Энэ хэний ном бүй. Энэ бол миний ном хэвлэл мөн билээ. Манай ам бүл олон болов. Миний ах Мөлөмын хөвгүүн хонь ямаа маллав. Хүн бүхэн ном авлаа. Миний авга ах болох хүн үүнийг хийв.

ХИЙХ - гэдгийг ᠬᠢᠬᠦ гэж бичнэ.

Дараахи үгсийг сайн ажиглаж ав!

(ид бахын)

(том баглын)

бал

(бөх тэмээний)

(бөх батын)

(бах хэр батын)

(бөх дүрийн хэр)

Үйл үгийн цаг заах төловийн өнгөрсөн цагийн нөхцөл -в- г монгол бичигт -ба(бэ) ᠪᠠ гэж бичнэ. Жишээ нь:

-лаа
-лоо

-лээ
-лөө

Ярианы хэлэнд ойртуулсан хэлбэрнь ᠯᠠ л-а л-э

VI хичээл

ᠩ	НГ (ŋ)
эхэн	ᠩ
дунд	ᠩ
адаг	ᠩ

Монгол бичигт хэлний үрдүүр, хойгуур хэлэгдэх Н – авиаг кирил үсэгт нэг үсгээр тэмдэглэсэн. Түүнийг ялгахын тулд ялгах эгшгийн дүрэм зохиосон. Гэтэл монгол бичигт өөр өөр дүрсээр тэмдэглэнэ. 1-р хичээлд үзсэн Н бол хэлний үрдүүрхи Н юм. Одоо үзэж байгаа хэлний хойгуурхи Н-авианы бүтэх орны Г-авиатай адил тул монгол бичигт тэр авиаг Н+Г гэсэн 2 үсгээр нийлүүлээр тэмдэглэдэг. Түүнийг их инхэлэг гэдэг. Эгшгийн өмнө буюу үгийн эхэнд тохиолдохгүй.

анг (ан)
энг (эн)
инг (ин)
онг унг (он, ун)
өнг үнг (өн, үн)
ланг лэнг (лан, лэн)
(лин) линг
лонг лунг (лон, лун)
лөнг лүнг (лөн, лүн)



Кирил галиг

монггол хэлэ, мингган. инггэ, онггон агула, ангхан-у ангги, нэнг хөнггэн, энгхэ мөнгхэ, ганганг. лонгху, өнггэ мөнггү, анг ангнаху, хоолахи хангаи, охи манглаи, эм-ун мангхаг

Хөрвүүлэг

Монгол хэл, мянган ингэ, онгон уул, анхны анги, нэн хөнгөн, энх мөнх, ганган лонх, өнгө мөнгө, ан агнах, холхи хангай, охь манлай, эмийн монхог (үүт)

Тайлбар:

-ГН- гэсэн нийлэмжийг монгол бичигт эмэгт —НГН— гэсэн нийлэмжээр бичдэг. ангнах = агнах

Дүрэм. Монгол хэлэнд нэр үгээс үйл үг бүтээдэг -Л дагавар бүй. Их идэвхтэй хэрэглэгддэг. Энэ дагаврыг монгол бичигт эмэгт ард нь а (э) эгшигтэй бичнэ. Жишээ:



Санамж: Н-ээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн нөхцөл залгахад дунд нь Г дуудагдаж байвал үг үгийг их инхэлгээр төгссөн гэж мэд! Жишээнь; САН + ИЙН = САН+Г+ИЙН Г гийгүүлэгч гарч ирж байгаа болохоор САН гэдэг үгийг их инхэлгээр төгссөн гэж мэд. ҮНЭН+ИЙ = ҮНЭНИЙ гэхэд Г гарч ирэхгүй. Тийм болохоор ᠨ (Н)-ээр төгссөн гэж мэдмүй.

VII, VIII ХИЧЭЭЛ	эхэн	дунд	адаг
т	ᠲ	ᠲ	"
д	ᠳ	ᠳ ᠳ	ᠳ
та,тэ да,дэ	ᠲᠠ	ᠲᠠ	ᠳᠠ
ти ди	ᠲᠢ	ᠲᠢ	ᠳᠢ
то,ту до,ду	ᠲᠣ	ᠲᠣ	ᠳᠣ
тө,тү дө,дү	ᠲᠥ	ᠲᠥ	ᠳᠥ

Үгийн дунд тохиолдох -д 2 хэлбэртэй, ᠳ — эгшгийн өмнө тохиолдох хэлбэр. ᠳ — гийгүүлэгчийн өмнө ордог хэлбэр. Өөрөөр хэлбэр Д-ийн дэвсгэрлэж орох хэлбэр ᠳ, ᠳ эдгээр болно. Бас үгийн адагт орох Д-ийн ᠳ ийм хэлбэр бий. Гэхдээ ᠳ ᠳ зэрэг хэдхэн үгэнд тохиолдоно.

Кирил галиг. бату табун тэмэгэ абуба. Ах-а далан табун адугу маллаба. ман-у нигэдул-ун мал хэду хэдун түмэ билэ. тал-а нутуг ту тэмэгэ олан. тэмэгэн-ү тол-и ботугу гэн-э. тол бухун-и мал болган-а. дамдин, дулам-а, готуб бугудэ атан тэмэгэ унуба. арад түмэн унэн-и магадлаба. та бухун тамахи бүү тата. тамахин-у утуг-а магухаи. бидэн-у нохуд олан.

Хөрвүүлэг. Бат таван тэмээ авав. Ах далан таван адуу маллав. Манай нэгдлийн мал хэд хэдэн түм билээ. Тал нутагт тэмээ олон. Тэмээний төлийг ботго гэнэ. Төл бүхнийг мал болгоно. Дамдин, Дулмаа, Готов бүгд атан тэмээ унав. Ард түмэн үнэнийг магадлав. Та бүхэн тамхи бүү тат. Тамхины утаа муухай. Бидний ноход олон.

Дараах үгсийг сайн нүдэлж, тогтоож ав!

утуга (утаа), удага (удаа), удх-а (утга), хойдох, хойтох, худдуг (худаг), хутаг (өлзий), шенег, елбенег, вехнех, хүүхэд, дүн, дү, нг, нэ, ху, хенлнь

Үсэг, үеэр нь задлан бич.

Хөрвүүлэг. Эвлэвэл бүтмүй. Хобловол гутмуй. Үг давтвал урчгэ. Ном давтвал билэг.

Задлах жишээ: ᠳ ду ч ч г } ᠳ гэх мэт.

IX ХИЧЭЭЛ

ᠷ	эхэн	дунд	адаг
р	ᠷ	ᠷ	ᠷ
ра / рэ	ᠷᠠ	ᠷᠠ	ᠷᠠ
ри	ᠷᠢ	ᠷᠢ	ᠷᠢ
ро / ру	ᠷᠣ	ᠷᠣ	ᠷᠣ
рө / рү	ᠷᠥ	ᠷᠥ	ᠷᠥ

<u>Кирил галиг.</u> радн-а, рабдан, мигмар, багатур, гарм-а, торубату нар нагадум дур хурдун мори унуба. хабур, намур-ун улаpил дур халагун наран гарба. аруханггаи, обурханггаи дур хур-а боруг-а оруба. улаганбагатур хота дур ном-ун дэлгэгур олан буи. гэр-ун дагаганга бури дур арбан дорбэн тог-а боду. тан-у нэр-э хэн буи? мину нэр-э тэмур.

<u>Хөрвүүлэг.</u> Радна, Равдан, Мягмар, Баатар, Гармаа, Төрбат нар наадамд хурдан морь унав. Хавар, намрын улиралд халуун нар гарав. Архангай, Өвөрхангайд хур бороо оров, Улаанбаатар хотод номын дэлгүүр олон бий. Гэрийн даалгаварт арван дөрвөн тоо бод. Таны нэр хэн бэ? Миний нэр Төмөр.

<u>Дүрмийн тайлбар</u>: Бүх тийн ялгалын нөхцөлийг өмнөх үгээс нь салангид бичдэг. Үүнийг байнга санагтун! Монгол бичгийн өгөх оршихын тийн ялгал [Mongolian script] тур / түр [Mongolian script] ту / тү [Mongolian script] дур / дүр [Mongolian script] ду / дү гэсэн нөхцөлтэй.

[Mongolian script] [Mongolian script] нөхцөлийг хатуу дэвсгэр буюу «багарсад»-аар төгссөн үгэнд залгуулна. Бусад бүх тохиолдолд [Mongolian script] [Mongolian script] нөхцөлийг залгана.

Жишээ нь:

хаварт	хотод	олонд	гэрт	номд	ардад	ахад	бидэнд	тожд	хүүхдэд	нэгдэнд

Тайлбар:
Нэгэн үгэнд [Mongolian script] [Mongolian script] хоёрын алийг ч дагуулж болно. Гэвч [Mongolian script] [Mongolian script] нь эртний хэлбэр.

X̲, X̲I̲ ХИЧЭЭЛ

ᠪ	эхэн	дунд	адаг
й(j)	ᠶ	ᠶ	ᠶ
йа йэ	ᠶᠠ	ᠶᠠ	ᠶᠠ
йи	ᠶᠢ	ᠶᠢ	ᠶᠢ
йо йу	ᠶᠣ	ᠶᠣ	ᠶᠣ
йө йү	ᠶᠥ	ᠶᠥ	ᠶᠥ
ж з	ᠵ	ᠵ	〃
жа,жэ за,зэ	ᠵᠠ	ᠵᠠ	ᠵᠠ
жи зи	ᠵᠢ	ᠵᠢ	ᠵᠢ
жо,жу зо,зу	ᠵᠣ	ᠵᠣ	ᠵᠣ
жө,жү зө,зү	ᠵᠥ	ᠵᠥ	ᠵᠥ

Үгийн дунд орох ж,з ᠵ – г ц,ч ᠴ-ээс сайн ялгаж мэд.

ᠵ ж,з ᠴ ц,ч



Кирил галиг. ойутан-у йарийа, йабаган йабуху, энэ йагун буи. энэ нигэн айаг-а, жагун жил, жун-у ажил, жиргал жоб жам-и жигаба. жужаган ном ужэбэ. ойидуб, найидан, буйанту, хайидуб, майидар-а, йондан нар үйлэдбүри-дүр ажил хибэ. ои-дур йабужу мойил тэгүжү, майихан дур хонуба. нохур-ун магу-йи харахубар өбэр-ун магу-йи хара.

Хөрвүүлэг. Оюутны яриа, явган явах, Энэ юун буй? Энэ нэгэн аяга. Зуун жил, зуны ажил, Жаргал зөв замыг заав. Зузаан ном үзэв. Ойдов, Найдан, Буянт, Хайдав, Майдар, Ёндон нар үйлдвэрт ажил хийв. Ойд явж, мойл түүж, майханд хонов. Нөхрийн муу г харахаар өөрийн муу г хар.

Тайлбар: Я, ё, е, ю – дөрөв бол [й(j) + эгшиг] гэсэн бүхэл үгийг тэмдэглэдэг үе үсэг юм. Монгол бичигт й(j)-гийг үүнийг тусгай үсэг(ᠶ)-ээр тэмдэглэх бөгөөд бичмэл хэлбэр нь этгээр шилбэ болов ч дармал бөгөөд хэлбэр нь үгийн эхэнд орох ж,з(ᠵ)-тэй адил шулуун шилбэ байдгийг анхаарогтун! Үгийн адагт орох и(ᠢ), й(ᠶ) хоёрын хэлбэр адил.

[Эгшиг + й(ᠶ) + и] – монгол бичгийн энэ нийлэмж нь орчин цагийн монгол хэлний эцсийн бус хос эгшигтэй дүйнэ. Жишээ нь: м + о+й+и + л = мойл ᠮᠣᠶᠢᠯ а+й+и+л ᠠᠶᠢᠯ айл. Дээрх жишээний О, а эгшгийн дараахи шилбэ нь й(ᠶ) гийгүүлэгч мөн бөгөөд харин И эгшиэтэй адил этгээргүй шилбээр бичдэгийг бусад жишээнээс ажиглана.

ᠢ { ᠢ й, ᠢ и } Энэнь заасхын тийн ялгалын нөхцөл бөгөөд эгшгээр төгссөн үгэнд дагуулна.

ᠪ { б, а~э, р } Үйлдэхийн тийн ял-галын нөхцөл бөгөөд эгшгээр төгссөн үгэнд дагуулна.

XII ХИЧЭЭЛ

ᠰ	эхэн	дунд	адаг
с	ᠰ	ᠰ	ᠰ
са сэ	ᠰᠠ	ᠰᠠ	ᠰᠠ
си	ᠰᠢ	ᠰᠢ	ᠰᠢ
со су	ᠰᠣ	ᠰᠣ	ᠰᠣ
сө сү	ᠰᠥ	ᠰᠥ	ᠰᠥ

<u>Хорвуулээ.</u> Худалгүй үнэн үг, хоргүй сайхан санаа, гоомойгүй бат явдал энэ гурвуул бүрдвээс мэргэний түйл. Морь унах хүнд жолоо хэрэгтэй. Эрдэм сурах хүнд самбаа хэрэгтэй. Агтын сайныг унаж мэддэг. Хүний сайныг ханилж мэддэг. Хүний тус бүтвээс өөрийн тус бүтмүй.

<u>Тайлбар.</u> Монгол бичигт хоёр эгшиг давхарлан бичиж, урт эгшиг тэмдэглэх ёс бүй. Уламжлалаар цөөвтөр үгийг ингэж бичнэ. Жишээ нь:

гоомой, ноос, ноорог, нугалан, онгоо, түүз, ууж(-ж), бууз, буур, зүүх, гүүрс, боор, ёотон, нүү, нүүдэн, бүү, бүү (зээл)

й, ч, н харьяалахын тийн ялгалын нөхцөл, эгшгээр төгссөн үгэнд залгагдана.

Богино эгшигтэй цөөн үгийг уламжлалаар эгшиг давхарлан бичдэг.

гол, хос, тор, хор (хорхойлох), хор (нохойн хор)

<u>Дараахи үгсийг ялган тогтоо!</u>

өвөр нийлсэн, өвөр нийлүүд, өөр (өөрийн бие г.м.), өөр (онгоо) =, сурах, суруулах нэгэн сурах, осуулах, лавлах, сурах, сорох, түсгэл түс түнэн, (хорголох сүүч)

XIII ХИЧЭЭЛ

	эхэн	дунд	адаг
т / д			
то, тэ / до, дэ			
ти / ди			
то, ту / до, ду			
тө, тү / дө, дү			

Хорвүүлэг. Ховч хүнтэй эрилцвээс хүний муу дуулах, худалч хүнтэй эрилцвээс өөрийн нь муу мэдэх. Чамд хүн ховлосон тэр хүн чамайг хүнд ховлох хүн болохыг мэдэгтүн. Хоёр нохойн хооронд яс битгий хая. Хоёр нөхрийн хооронд хов битгий хэл.

1 2 3 4 5 6 7 8 9 10 100 1000 10000 100 000 сая живаа

Дараах үгсийг ялган тогтоогтун!

дуулах (дуу дуулах)
дуулах (сонсох)
асар (мойхон мэт)
асар— (тэтгэ—)
асар (их)
асури (домгийн)
хэрэм (хана)
хэрэм (амьтан)
хээр (морины зүс)
хээр (ходоо)
хэт (хэт цахиурын)
хэт (алс хэт)
аргал (түлш)
аргаль (амьтан)
аргал— (үйл үндэс)
аргалах

Хамтрахын тийн ялгал:

т, а(э), и — тай 3

аавтай ээжтэй морьтой лугa лугэ

-тай? = ... = ... дуу лугээ дуутэй

чам лугаа = чамтай

XIV ХИЧЭЭЛ

[Mongolian script]	эхэн	дунд	адаг
ш	[Mongolian script]	[Mongolian script]	•
ша шэ	[Mongolian script]	[Mongolian script]	[Mongolian script]
ши	[Mongolian script]	[Mongolian script]	[Mongolian script]
шо шу	[Mongolian script]	[Mongolian script]	[Mongolian script]
шө шү	[Mongolian script]	[Mongolian script]	[Mongolian script]

[illegible]

Багшийн шаардлага, шавийн хичээл нэн чухал шүү. Шүүгээ дотор судар шастир олон бий. Шог хошин зохиолын шагналыг Шагдар олгов. Шатаар шаламгай гүйв. Шаазгай шувуу шаг шаг гэнэ.

[illegible] { ч, й, а~э, р } Гийгүүлэгчээр төгссөн нэр үгэнд дагуулах үйлдэхийн тийн ялгалын нөхцөл

[illegible]
[illegible]
зохиолоор
[illegible]
хүнээр

[illegible] { а~э, г, а~э } Гарахын тийн ялгалын нөхцөл

«Алтан товч» хэмээх шастираас

[illegible]

Биеийг нь хуурахаас сэтгэлийг нь хуураагтун. Сэтгэлийг нь хуураваас бие нь хаана одох, Бие бөх бөгөөс гагцыг ялгуу юу, Сэтгэл бөх бөгөөс олныг ялгуу юу. Мах идэх шүд аманд аюу. Хүн идэх шүд сэтгэлд аюу.

Үгийн тайлбар:

[illegible] оху (ох)
[illegible] огсон
[illegible] огоод
[illegible] одоос
[illegible] одо
[illegible] олон
[illegible] ежо
[illegible] жо
[illegible] ожиду

[illegible] { а, юу }

[illegible] юу, юу

Энэ нөхцөл нь ирээдүй цагийг заана.

Дээрх үгсийн язгуур а— бол бай— гэсэн үйл үгийн язгууртай адил утгатай. Жишээнь: атээж байжээ.

Үгийн тайлбар: Ялгуух гэдэг нь бүрмөсөн дийлэх гэсэн утгатай байна

XV ХИЧЭЭЛ

[illegible]	эхэн	дунд	адаг
в	[illegible]	[illegible]	[illegible]
ва вэ	[illegible]	[illegible]	[illegible]
ви	[illegible]	[illegible]	[illegible]
во ву	[illegible]	[illegible]	[illegible]
вө вү	[illegible]	[illegible]	[illegible]

[illegible]

Хөрвүүлэг. Ванчиг гуай баар совонг айраг хийв. Вандан, Вандуй, Агваан, Цэвээн, Даваа хэмээх хүний нэр цөм төвд үг болой. Очир аймаас болбоос хамгаас хатуу эрдэнийн чулуу юм. Нацагдорж гэдэг үгийг Элдэв-Очир хэмээн орчуулмуй. Ван, гүн хэмээх нь цол хэргэмийн нэр болой.

Үгийн тайлбар:

Энэтхэгийн санскрид хэлний ВАЖРА гэдэг үг согд, уйгар хэлээр дамжиж ирсэн нь ОЧИР болж, төвд хэлээр дамжиж ирсэн нь БАЗАР болсон. Монгол бичигт согд, уйгар уламжлалыг баримтлан ВЧИР гэж бичдэг.

Дүрмийн тайлбар:

[illegible]

чухуй
чүхүй } — чээ

жухуй
жүхүй } — жээ

Үйл үгийн өнгөрсөн цагийг заах нөхцөл

Хатуу дэвсгэр буюу «багарсад»-аар төгссөн үгэнд чухуй (чүхүй)-г залгана. Зөөлөн дэвсгэр болон эгшгээр төгссөн үгэнд жухуй (жүхүй)-г залгана. Жишээ нь:

одчээ — од
ирчээ — ир
[illegible]
тогтчээ — тогт
[illegible]
[illegible]
болжээ — бол
хийжээ — хий

Энэ мэт үгийн -у,-ү эгшгийг ва - дэвсгэр гэдэг. Энэ нь учиртай бөгөөд эртний монгол хэлэнд -у,-ү бус в (w) гийгүүлэгч байжээ.

Жишээ нь:

тэвхэ → тэухэ
тавлаи → таулаи

Таулай = Туулай
Тэухэ = Түүх
[illegible]
[illegible]

XVI, XVII ХИЧЭЭЛ

Гадаад үгэнд ордог зарим үсгээс

ф	ᠹ
п	ᠫ
к	ᠻ
ц	ᠼ
з	ᠽ
ж	ᠵ
х(h)	ᠾ
лх	ᡀ
е, э	ᠧ

Гадаад үгийг бичих гол зарчим бол тухайн хэлний бичлэг, дуудлагад ойр бичихийг хичээдэг. Товонхийн шүргэх - h(х) авиаг монгол бичигт ᠾ-ийм дүрсээр тэмдэглэнэ. Харин орос хэлэнд -Г- үсгээр бичдэг. Жишээ: Hawana = Гавона

Гадаад үгэнд орох -д, -т үсгийг үгийн хаана ч орсон дүрс хувилгаагүй бичнэ.

ᡊ ᡊ ᡊ } д ᡈ ᡈ ᡈ } т

кино
мастер
феодал
килограмм
систем
сантиметр
Москва
столиц
философи
лекц
радио
курс
депутат
пролетари
Ленин
Маркс
интернационализм

фото
фронт
цемент
техник
фабрик
азот
кабинет
процент
контор
фонд
паспорт
профессор
капитализм
редактор
практик
социализм
коммунизм

Лхамсүрэн
Лхүндэв
Лхүндэв
Лхагва
Лхом
Лхас
Гибрид
гуманизм
Гималай
Ханой
Прага
Генрих
Габона
Хлор
Хром
Голланд
Хүннү гэх
(Хүннүг)

XVIII ХИЧЭЭЛ

Тийн ялгалын нөхцөлийг хэрхэн дагуулсныг ажигла, тогтоо!

Хөрвүүлэг. Хэний номыг авав? Дамдины номыг авлаа. Хэнд ном өгөв? Норовд бас Дондовд ном өгөв. Хэнийг багш дуудав? Бадамыг багш дуудав. Хэнээр багш самбар дээр бичүүлэв? Самбуугаар бичүүлэв. Хэнээс дэвтэр авав? Аюушаас дэвтэр авав. Хэн лүгээ (хэнтэй) хамт ирэв? Цэдэв лүгээ хамт ирэв.

нэрлэх ю.о. гарах хамтрах

харьцах заах үйлдэх

Дүрэм.

Үйлт нэрийн өнгөрсөн цагийн нөхцөл.

-гсан -гсэн

Гийгүүлэгчээр төгссөн үйл үгийн үндсэнд залгавал гээс жийрэглэнэ.

- сан
- сон } -гсан

- сөн
- сэн } -гсэн

Сануулга: Зөв бичиж чаддаг болсон үгээ олон дахин бич!

XIX ХИЧЭЭЛ — Нэрийн хамаатуулах ёс

ерөнхийлэн хамаатуулах	Гурван биед хамаатуулах		
	I бие	II бие	III бие
[Mongolian script]	[Mongolian script]	[Mongolian script]	[Mongolian script]
-ээ -оо -өө -аа	минь, маань	чинь, тань	нь
[Mongolian script] ээжээ, [Mongolian script] охиоо; [Mongolian script] номоо, [Mongolian script] нөхрөө	[Mongolian script] ээж минь, [Mongolian script] охин минь; [Mongolian script] нөхөр маань, [Mongolian script] ном маань	[Mongolian script] ээж чинь, [Mongolian script] ох чинь; [Mongolian script] ном чинь, [Mongolian script] дэвтэр тань, [Mongolian script] ном тань	[Mongolian script] гэж бичихдээ, тодорхой-ну-эм учир, ону-эрүүлд; [Mongolian script] ох нь, [Mongolian script] ээж нь, [Mongolian script] дэвтэр нь

Монгол хэлэнд, нэр үгийн хойно зохих нөхцөлийг дагуулж, уул юм хэний болох, хэнд хамаатай болохыг үзүүлдэг. Тэдгээр залгаврыг хамаатуулах нөхцөл гэх бөгөөд гурван биед хамаатуулах, өрөнхийлөн хамаатуулах нөхцөл гэж хоёр хуваадаг.

[Mongolian script] — б, а~э, н — эгшгээр төгссөн үгэнд дагуулна. [Mongolian script] — и, й, а~э, н — гийгүүлэгчээр төгссөн үгэнд дагуулна.

[Mongolian script]

Хөрвүүлэг.

Аав минь морио унаад хонио хариулж явна. Найз чинь номоо аваад явсан. Багш тань ирэв. Энэ нэгдлийн тэмээ нь олон, адуу нь цөөн ажээ. Гараа угаагаад, хоолоо идэв. Тоглоо бодож, номоо уншив. Үгний утга нь сайхан. Үнэгний үслэг нь сайхан. Хойр нь дотроо, хал нь гадаа.

[Mongolian script] — у, хч, йа, ху — угаах гэдгийг ингэж бичнэ.

XX хичээл

Хамаатуулах нөхцөлтэй тийн ялгал

Н.	Х.	Ө.о.	З.	Г.	Ч.	Ха.

Хатуу дэвсгэрээр төгссөн үгэнд дагуулна.

Зөөлөн дэвсгэр болон эгшгээр төгссөн үгэнд дагуулна.

Сануулга:
Тийн ялгалын нөхцөл, хамаатуулахын нөхцөлийг монгол бичигт саланги бичдэгийг ямагт анхаар!

XXI ХИЧЭЭЛ

Олон тооны дагаврыг зөв бичих ёс

нар

-чүүд

-чуд

-чүүл

-чуул

-д

-с

Бага инхиэг буюу (н, мөн эгшгээр төгссөн үгэнд эр, эмийг баримтлан дагуулна.

Н-ээс бусад гийгүүлэгчээр төгссөн

Нүгүд гэдгийн эхний үеийн Ч-гийн шилбэ бичдэггүй.

Дүрэм

Гийгүүлэгчээр төгссөн үйл үгийн үндсэнд эгшиг авхуулагч дагаврыг залгахад у,ү эгшиг буюу гэдэж жийрэглэнэ. Үүнийг жийрэглэх эгшиг буюу холбох эгшгийн дүрэм гэнэ. Тэрхүү эгшиг авхуулагч дагаврыг хойно жагсаасан буй. Монгол бичгийн гол дүрмийн нэгэн энэ юм. Энэ дүрмээр зөв бичихэд юуны өмнө гийгүүлэгчээр төгссөн үйл үгийн үндсийг тогтоох хэрэгтэй. Харин ав-, хөв-, жив-, ог- гэсэн үйл үг өөр хувилалтай. (Зарим тохиолд)

-ба(бэ) нөхцөл эгшиг авхуул- дагчгүй байвч д-ээр төгссөн үйл үгэнд залгахад гэдэж, үе жийрэглэнэ.

XXII ХИЧЭЭЛ

Төлөөний үгийг зөв бичих

Хөрвүүлэг. Би, миний, надад, намайг, надаар, надаас, надтай, над лугаа, чи, чиний, чамд, чамайг, чамаар, чамаас, чамтай, чам лугаа, та, таны, танд, таныг, танаар, танаас, тантай, тан лугаа, бид, бидний, бидэнд, биднийг, биднээр, биднээс, бидэнтэй, бидэн лугээ, та нар, та нарын, та нарт, та нарыг, та нараар, та нараас, та нартай, та нар лугаа, энэ, үүний, үүнд, үүнийг, үүгээр, үүнээс, үүнтэй, үүн лугээ тэр, түүний, түүнд, түүнийг, түүгээр, түүнээс, түүнтэй, түүн лугээ.
Ийм, тийм, энд, тэнд, өдий, төдий, хэдий, хэд, өчнөөн, төчнөөн, хэзээ, хаана, нөгөө

Нөхцөл үйл үгийн нөхцөлөөс:

-жу -чу
-жү -чү
-ж
-ч

Хатуу дэвсгэрээр төгссөн үгэнд -чу(чү)-г залгана. Бусад тохиолдолд -жу(жү)-г залгана. Энэ нөхцөл нь эгшиг авхуулдаггүй тул тийрүүлэгчээр төгссөн үйл үндсэнд шууд залгана.

-гсагар
-гсэгэр } -саар[4]

Эгшиг авхуулдаг нөхцөл.

XXIII ХИЧЭЭЛ

Гийгүүлэгчээр төгссөн үйл үгийг хувилгах жишээ:

гар-

Хорвуулэг. Гарах, гарчээ, гардаг, гарав, гарвай, гарвал, гарваас, гарахул, гартугай, гартал, гаравч, гарахлаар, гархуйя, гарга, гарцгаа, гархуйц, гарсугай, гарамгай, гартах (хэлж дийлэгдэх) гарч ←

Гарна, гарнам, гаран одов, гарангуут, гарамгүй, гармаар, гармуй, гармагц, гарсан, гарагч, гарагтун, гарсаар, гараг (эвэг), гарал, гарур-а (гарахаар) одов, гарлаа, гаралт, гарлага, гаралтай, гаръя, гаръюу (гарна), гарщгүй, гараарай, гараасай, гараач, гараад, гаруузай, гарууштай, гараагүй, гараадүй (гараагүй)

Тайлбар:

① сураадүй сураагүй
② хүрээдүй хүрээгүй
③ олоодүй олоогүй
④ төгсөөдүй төгсөөгүй
⑤ судлаадүй судлаагүй

-аагүй⁴- нөхцөл нь эгшиг авхуулна. Өөрөөр хэлбэл гийгүүлэгчээр төгссөн үйл үгийн үндсэнд залгахад гэсэн жийрэглэнэ.

Гийгүүлэгчээр төгссөн үйл үгийн үндсээс

- айлдах
- овдох
- үүдэх
- одох
- үйдах
- үдирдах
- устах
- үйлдэх
- наадах
- нэгдэх
- бэлдэх
- бүрдэх
- зантидах
- жолоодох
- дадах
- мороодох
- цадах
- анхаарах
- үүрэх
- хавсрах (хуурай шуурах)
- хавсрах (хүч нийлэх)
- дуугарах
- хамаарах

- хамрах
- хоцрох
- хүрэх
- зохирох
- дүүрэх
- чирэх
- үүсэх
- омсох
- урсах
- өсөх
- унсэх
- нисэх
- босох
- хийсэх
- тогсох
- дуусах
- дасах
- дурсах
- сонсох
- баясах
- судлах
- тайлах
- арилах

Гийгүүлэгээр төгссөн үйл үгийн үндсэнд эгшиг авхуулаг нөхцөл, дагаврыг залгахад гэдэс (у~ү эгшиг) жийрэглэнэ. 23-р хичээлийн ГАР- үйл үгийн хувилгааг үзнэ үү!

усадха- [illegible] уст- устга-, [illegible] бэлэг- [illegible] бэлэгхэ- бэлд- бэлтгэ-,
гийгүүлэгчээр төгссөн үйл үгэнд залгана. Ж: усад- [illegible] -
хүргэ-), [illegible] (х-а) [illegible] хэ Мөн хэвийн нөхцөл боловч С, Д -
([illegible]) хэвийн нөхцөл Ж: [illegible] - [illegible], гар - гарга-, [illegible] - [illegible] хүр-
[illegible]
[illegible] (суруулга-) [illegible]
-аар төгссөн үгэнд залгана. Ж: [illegible]
эхэлсэн эгэээр нөхцөлийг хатуу дэвсгэр буюу «батарсад»
[illegible] (эвдүүлгэ-) [illegible] дээ- эээр
төгсөөгүй үгэнд залгана, Ж: [illegible]
жу², жухуи², жэи, жаг-а² нөхцөлийг хатуу дэвсгэрээр
[illegible] - ээр эхэлсэн
([illegible]) [illegible] (хэвийн), [illegible]
[illegible] : [illegible]
[illegible]
[illegible] чир- чируул, [illegible] бос - босуул,
[illegible] хотол- хотлуул, ② нэр үг бүтээх дагавар жишээ:
① хэвийн нөхцөл | жишээ: [illegible] тайл - тайлуул, [illegible] -
[illegible] -гул, -гүл нь 2 янзбүй,
[illegible]
([illegible]) (уртатгалын) [illegible]
[illegible]
[illegible] (-лд хэвийн) [illegible]
[illegible]
[illegible]
[illegible] : [illegible]

Тэргүүн үедээ «И» эгшигтэй үгсээс (Одоо дуудлага өөр болсон тул тогтоогтун!)

яруу	нүд	хясаа (усны амьтан)
ярах	нударга	хясаа (хад хавцал)
ятгалга	нудрах	хясах
ятгах	удган (эм бөө)	хялгас
ялзмаг	ноднин	хямд
ялзлах	нядлах	хямрал
ялгал	нусхай	хямрах
ялгаа	нус	хумс
ялгавар	няслах	хянах
ялгах	нялхас	бяр (чадал)
ялгуух– (бүрмөсөн дийлэх)	няях	бяцрах
ялаа	нулимс	бяцхан
ялаат	нялуун	бядуу (дорой)
ялах	нямбай	бясалгах
ялангуяа	ням (гариг)	бяслаг
ялуу (тэргэнэй)	нягтлах	бялдууч
ямагт	нягт	бялхах
ямаа	нүгэл	бямба (гариг)
ямх	нүүр	нухах
явцуурах	нууц	нярав
явцуу	нуугдах	нуруу
явуу	нүүх	нярай
янзага	яргуй	нуцгэн
янцгаах	ерөөл	няцаалт
янаг	ерөөх	няцах
наана	ёроол	няцлах
ноод	ёр (сайн ёр муу ёр)	няц
инагш (наагш)	эралзах	нүдлэх

шунах	шуурхай	шарах (тулэх)
шаналах	шуудай	шар (өнгө)
шанага	шууд	шүд
шуудан	шуух (бахах)	шударга
лянхуа	шугуй	шүтээн
мяраан (эрээн)	шээс	шүтэх
мяралзах	шаар (хог)	шадар (дотно)
мятрах	шүхэр	шатар (тоглоом)
мялаах	шахам	шатахуун
мягмар (гариг)	шахуу	шатах
миагуй (муур)	шахах	шаятгаан
мах	шувтрах (сахлаа)	шалтаг
мяндас	шувтрах (дуусах)	шалгалт
мянга	шувтлах	шалгах
гярхай	шувт	шалдархай
гялтайх	шавхруу	шүлс
гялбаа	шавхрах	шүлүүс
гялбах	шовог	шүлэг
гялалзах	шавар	шулуун
гялгар	шавьж	шамдгай
хяргах	шувуу	= шулмас
хяроо	шаваг (ургамал)	шуурэх (булаах)
хяруу	шавах	шүүдэр
хяр (цулын хяр, эмээлийн хяр)	шормос	шүүс
хязгаар	шандас	шүүгэх
хядах	шантрах	шүүмж
хутга	шунал	шүүх
хятад	шунахай	шуурга

царай	журам	ямар
чөтгөр	зурхай	хүүхэд
цутгах	зураг	гариг
чөдөр	зурах	өглөө
чадах	жороо	тэнгэр
цус	зүтгэл	тавих
чөлөө	зүтгэх	дүгнэх
чулуу	жад	дун
чөмөг	жөтөө (атаа)	үтэр (түргэн)
чуулган	зүслэх	үүх
чуулах	зүс	гэнэт
чухал	зусар	худаг
цухал	жолоч	уйлах
чандага	жолоо	угаах
чанд	жалга (гуу)	хаана
чанга	жагсаал	хамар
чагнах	жагсах	хир (буртаг)
чоно	зуурах	хив (торго)
чанар	зугатах	агшин
цааш	жуулчин	
чанах	зуух (амь)	
шургах	заар (худрийн)	үрэл
шоргоолж	загас	живаа (тоо)
шаргуу	заавар	жартгай
шарга (зүс)	заах	зургаа
шарх	зэвүүн	жаргал
шарвах	жавхлан	жаргах
шороо	жавар	зүрх

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible] (байсанд)

[illegible]

(ухэлах — бусдын оо сэвийг эрэлхийлэх)

[illegible]

(бадгой)

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

᠙ . [illegible]

᠑᠐ . [illegible]

᠑᠑ . [illegible]

᠑᠒ . [illegible]

᠑᠓ . [illegible]

᠑᠔ . [illegible]

[illegible]

([illegible])

[illegible]

ЭРДЭНЭ МЭТ ҮСГИЙГ ХЯЛБАР ЭВЛҮҮЛЖ ЧИМЭГ БОЛГОН ХЭРЭГЛҮҮЛЭХ АМАР ХӨТӨЛБӨР ОРШИВ

...Нэрсийг холбож үг (үг өгүүлбэр Ш.Ч) болгох нь: Наран ургаваас ертөнц гиймүй. Эрдэм сурваас хүмүүс гэгээрмүй. Наран сөнөвөөс (шингэвээс Ш.Ч) харанхуй болмуй. Хичээл (шамдал Ш.Ч) сөнөвөөс (үгүй болбоос Ш.Ч) тэнэг болмуй. Хатуужиж ирвээс баян болмуй. Хичээж шамдваас эрдмийг сурмуй. Дуслыг хурааваас сав дүүрмүй. Сурсныг хурааваас мэргэн болмуй. Алтыг нухваас улам гялалзмуй. Хичээлийг эрхэмлэвээс улам мэргэшмүй. Нүүрсийг нухваас улам харламуй. Залхууг эрхэмлэвээс улам мунхармуй. Эдийг эдлэвээс барагддаг. Эрдмийг эдлэвээс хөгждөг. Баялаг хүмүүсийг тэнэгүүд хүндэлмүй. Эрдэмт хүмүүсийг мэргэд хүндэлмүй. Мунхаг болбоос насад (насан турш Ш.Ч) зовмуй. Эрдэмт болбоос насад (насан турш Ш.Ч) жаргамуй. Эрхтэн доройтвоос нөхөд гээмүй. Эрдэмтэй болбоос үл ганцаардмуй хэмээх мэт амуй.

Үлгэр утгыг барилдуулах нь:

1. Бичиг үл мэдэх нэгэн хүн өөрийг ал хэмээсэн бичгийг бусад нэгэнд өөрөө хүргэж алагдвай хэмээмүй.

2. Эцэг эх ба багш нар нь бичгийн эрдмийг сургахыг хичээвч бичгийн тус нь маш хол тул хожмын өөхөөс өдгөөгийн уушиг тустай хэмээж эс сураад худалдаа гүйлгээ зэрэгт шамдсан нэгэн хүн хожим хөл нь хугаран машид доройтсон нэгэн цагт өөр нэгэн хүн өдгөө надад бичүүлэх онц хэрэгт бичиг олон аху (байх Ш.Ч) тул тэдгээрийг бичиж өгвөөс насад (насан турш Ш.Ч) хэрэглэх хөрөнгө таслан өгмүй хэмээсэнд тэр бээр: аяа би гагцхүү хөлгүй болов хэмээсэн билээ. Хэдийнээ гаргүй ч болсон аж. Халаг хуухай! хэмээн гаслан сууж гашуун зовлонг ихэд амсвай хэмээмүй.

3. Хоёр замын уулзар (уулзвар Ш.Ч) дээр, баруун замд дээрэмчин буй. Зүүн замд аюулгүй хэмээсэн бичиг агсанаа (байсанд Ш.Ч) бичиг үл мэдэх нэгэн хүн түүнийг нүдээр үзэвч, үл мэдэхийн эрхээр баруун замаар явж, хамаг эдээ дээрэмчинд булаагдвай хэмээмүй. Тиймийн тул бичгийг хэрхэвч сурваас зохимуй.

4. Хураасан эдийг хулгайд алдаж болмуй. Сурсан эрдмийг хулгайд үл алдмуй хэмээжээ. Тиймийн тул хулгайн аюул ирж болох эдийг эрэхийн чөлөөнөөс (эд хөрөнгө олохоор зүтгэх цаг заваас Ш.Ч) хасаж, хулгайн аюул үл ирэх эрдэмд хичээвээс зохимуй.

5. Илжирхий идээнд ялаа батгана цугларахаас бус гоорхог (гоё сайхан Ш.Ч) амьтан үл тоомуй. Түүнчлэн мунхаг хүнд тэнэг хүн цугларахаас бус эрдэмтэн үл тоомуй хэмжээжээ. Тиймийн тул эрдэм сурч ямагт эрдэмтэн лүгээ (эрдэмтэнтэй Ш.Ч) нөхөрлөн жаргаваас зохимуй.

6. Илжигний чихэнд ус ба тос алиныг агуулбаас (хийвээс Ш.Ч) ялгалгүй сэгсэрмүй. Түүнчлэн мунхаг хүнд туст, хорт алиныг өгүүлэвч ялгалгүй орхимуй хэмээжээ. Тиймийн тул туст, хортыг сайтар ялгахын оньсот арга болох эрдэмд чармайн зүтгэвээс зохимуй.

7. Ой шугуйн дотор ямар мэт хашхиравч дуурайн шуугилдахаас бус үл дуурайх зүйл огт үгүй. Түүнчлэн тэнэгүүдийн дотор эрдэмт хүн туст, гэмт алиныг сургавч зөвшөөрөхгүй зүйл огт үгүй хэмээжээ. Тиймийн тул, эрдмийг сурч үгийн утга чанарыг сайтар таниваас зохимуй.

8. Чихэр бурам амтлаг болович хог буртаг лугаа (буртагтай Ш.Ч) хольцолдвоос хэн хэрэглэмүй. Эрдэм соёл тустай болович хэдэр догшин лугаа (догшинтой Ш.Ч) хольцолдвоос хэн хэрэглэмүй хэмээжээ. Тиймийн тул, эрдмийг сурагчид хэдэр догшин занг шамдан тэвчиж, эелдэг занг эрхэмлэвээс зохимуй.

9. Могой өтөг (баавгай Ш.Ч) тэргүүтнийг хэн ч үзвээс эмээмүй. Энэрэлт мэргэдийг хэн ч үзвээс баясан дуршмуй хэмээжээ. Тиймийн тул хорт муу сэтгэлийг тэвчиж туст сэтгэлийг эрхэмлэвээс зохимуй.

10. Гал хэдий их тустай болович догшин салхи лугаа (салхитай Ш.Ч) нөхөцвөөс (учирваас Ш.Ч) хөрөнгийг сүйтгэмүй. Эрдэмтэн хэдий их тустай болович нэн шунахай лугаа (шунахайтай Ш.Ч) нөхөцвөөс улсыг доройтуулмуй хэмээжээ. Тиймийн тул ховдог шунахай сэтгэлийг насад (насан турш Ш.Ч) цээрлэвээс зохимуй.

11. Зуудаг нохой эзэндээ тустай болович бусдыг хорлохуй нь үнэхээр бэрх. Зусарч хүн ихэст тустай болович доордсыг хөнөөх нь үнэхээр бэрх хэмээжээ. Тиймийн тул ураг садан ба нэгэн аймагтан хийгээд баяд ихсийг дотнолон, бусдыг хөнгөтгөх сэтгэлийг яаран тэвчиж, тэгш сэтгэлийг эрхэмлэвээс зохимуй.

12. Зарц хүн малын сайныг тэжээж мууг орхивоос эрхгүй хөөгдмүй. (Малын эзэн тэр тэнэг зарцыг хөөн явуулна. Ш.Ч) Албаны хүн ардын заримыг тэтгэж заримыг доромжилбоос эрхгүй жигшигдмүй хэмээжээ. Тиймийн тул ялангуяа улсын сангийн цалинг хэрэглэж бүхүй цагт тал нүүр харах (тал тохой татах Ш.Ч) сэтгэлийг нэн жигшиж тэвчвээс зохимуй.

13. Өөрөө өмдгүй бөгөөтөл бусдын өвдөгний цоорхойг элэглэвээс инээдтэй. Өөрөө их гэмт бөгөөтөл бусдын өчүүхэн гэмийг ухчилбаас (бусдын өө сэвийг эрэлхийлбээс Ш.Ч) инээдтэй хэмээжээ. Тиймийн тул анх өөрийн гэмийг сайтар шүүмжлэн цэвэрлэсний хойно бусдын гэмийг шүүмжилбээс зохимуй.

14. Зандан мод хэдий сайхан үнэртэй болович хорт могой ороовоос хэрэглэж үл болмуй. Эрдэмтэн мэргэд хэдий их тустай болович муу нөхөртэй нөхөрлөвөөс хэрэглэж үл болмуй хэмээжээ. Тиймийн тул уруу татагч муу нөхдийг хорт идээ мэт нэн үтэр тэвчвээс зохимуй.

15. Зусарч нохой хээнцэр хүмүүст янаглан шарвалзмуй. Тэнэг эх гоо хүүхдээ (зөвхөн царай зүс сайтайг нь Ш.Ч) үлэмжхэн асармуй. Бялдууч хүн ихэс лүгээ (ихэс дээдэстэй Ш.Ч) найрамдаж доордсыг дарламуй. Шударга мэргэд ядуу буурайгаа үлэмжхэн тэтгэмүй хэмээжээ. Тиймийн тул өнгөч бялдууч занг жигшин тэвчиж ядуу буурайгаа идэвхийлэн асарваас зохимуй.

16. Архи амтлаг боловч уугчдыг бүрэлгэх хүчин буй. Өнгө (алиа самуун явдал Ш.Ч) бахтай боловч шунагчдыг сөнөөх хүчин буй. Наадам зугаатай (мөрийтэй тоглоомыг хэлж буй Ш.Ч) боловч хөрөнгийг сүйтгэх хүчин буй. Эрдэм бэрх боловч сурагчдыг тэтгэх хүчин буй хэмээжээ. Тиймийн тул архи, өнгө, наадамд нэн шунах сэтгэлийг тэвчиж ямагт эрдэмд хичээвээс зохимуй.

Хэмээсэн үүнийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Судар бичгийн хүрээлэнгийн төвд үсгийн орчуулагч ба, оюутны сургуулийн монгол бичиг сургагчийн хүнд нэрийг хүлээсэн, Богд хан уулын аймгийн Булган хан уулын хошууны Шагж хэмээх бээр өөрийн зохиосон Эрдэнийн сангийн түлхүүр хэмээх үсгийн гүйцэтгэл (гүйцээсэн хэсэг Ш.Ч) болгож бичвэй.

(Үүнийг монгол улсын арван долдугаар (1927) оны зургаан сард Улаанбаатар хотноо нэгэн мянган хувь хэвлэн гаргажээ.)

Билгийн нүдэн тань тэгширч
Бичгийн үйлс тань дэлгэрэг!

[illegible]

Инжаннашийн "ХӨХ СУДАР" хэмээх гурамсан романы тэргүүн дэвтэр
"ТОВЧИЛТ ТОЛТ"-оос

[illegible]

[illegible]

[illegible]

[illegible]

Шаравын Чойжаа

Монгол бичиг

(сурах бичиг)

Нэмэн дэлгэрүүлсэн гурав дахь хэвлэл

Улаанбаатар
2002